



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/207

Улаанбаатар хот

Улсын комисс томилон ажиллуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.13, Эрчим хүчний сайдын 2019 оны 125 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам”-ын 3.2, “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 1/636 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Дулааны станц (Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон)” барилга угсралтын ажлын 10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, 10/0.4 кВ-ын хаалттай дэд станцын барилга угсралтын ажил дууссантай холбогдуулан уг барилга байгууламжийг хэсэгчлэн ашиглалтад хүлээн авах Улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсугай.

Комиссын дарга:

Д.Батзориг

Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн дарга

Гишүүд:

Р.Ширчинням

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнгөнцэцэг

Хэнтий аймгийн Архивын тасгийн дарга, архив албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч

Б.Наранцацрал

Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад

Т.Жанчив

Хэнтий аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Л.Батхүү

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн Захиалагч, техник хяналтын хэлтсийн дарга

Н.Даваасүрэн

“Багануур Зүүн Өмнөд Бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Дотоод хяналтын хэлтсийн Түгээх үйл ажиллагаа хариуцсан хяналтын инженер

Б.Одбаяр

“Багануур Зүүн Өмнөд Бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Хэнтий ЦТС-ын Түгээх үйл ажиллагаа хариуцсан менежер

17060000487

Б.Энхээ

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ-ын
зураг төслийн инженер бөгөөд зургийн зохиогч
(зөвшилцсөнөөр)

Т.Пүрэвдорж

“Энерго сервис монтаж” ХХК-ийн гүйцэтгэх захирал
бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэгч
(зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Ч.Оюунболд

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн Захиалагч,
техник хяналтын хэлтсийн инженер.

2.Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлыг зохион
байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахыг Улсын комисс (Д.Батзориг)-
т даалгасугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН